



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/13

Хөхбүрд

Захирамж залруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйл 33.1.2 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 80 дугаар захирамжийн хавсралтад заасан Эмнэлэг (9008349 регистрийн дугаартай)-ийн газрын хэмжээ 8156 м² байсныг хүчингүй болгож, одоо байгаа газрын хэмжээ 8178 м² хэмжээгээр болгож кадастрын бүртгэлийг шинэчилсүгэй.

2.Газар эзэмшигч Эрүүл мэндийн төвд газар эзэмших эрхийн гэрчилгээг залруулж дахин олгож, гэрээ байгуулж, газрын эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Газрын даамалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (н.Ганзориг)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Г.Ганцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ЖУХАТАНБААТАР

642201177